СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3834

2019.4.23 № 2/180

танай ______________-ны № ______________-т

ГАЗАР, ХЭЛТЭС, АЛБАДЫН
ДАРГА НАРТ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө болон Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай аймгийн Засаг даргын 2019 оны А/149, А/150 дугаар захирамжийг тус тус хавсралтаар хүргүүлэв.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг хугацаанд нь нэгтгэн ирүүлнэ үү.

Хавсралт 14 хуудас.

ДАРГА Ө.СУВДАА

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
## ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр Дугаар А/150 Сүхбаатар сум

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг
2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6.2, аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 3.2.7 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг тайланг 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор тайлагнахыг сум, агентлагийн дарга нар, нийт төр, төсөв орон нутгийн өмчийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ОРГИЛ

БАТЛАВ
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ш.ОРГИЛ

2019 оны ..04...-р сарын ..19....-ны өдөр.

МЮА0005 9055053

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөтөлбөрийн зорилго: Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

| Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.1.1.Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх; | 1 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | Дүгнэлтүүд нээлттэй ил тод болсон байх | Дүгнэлтийг ил тод болгох ажил хэвшсэн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| | 2 | Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн, төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод нээлттэй болгох | Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх | Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болгох ажил хэвшсэн байна. | АЗДТГ-ын ТЗУХ, ХЭЗХ | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур | 3 | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын | Албан тушаалтанд тавигдах шалгуурыг | Шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх | АЗДТГ-ын ТЗУХ, ХЭЗХ, Ёс зүйн хороод | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх; | | ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | шинэчилсэн байх | тогтолцоо бүрдсэн байна. | | байгууллага, ОНӨААТҮГ |
| 4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх; | 4 | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ хэлбэрт шилжүүлэх | Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх | Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүн сайжирсан байна. | АЗДТГ-ын ТЗУХ, ХЭЗХ, Ёс зүйн хороод | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 4.1.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх. | 5 | Авлигын эсрэг хууль тогтоомжоор давтан сургалтыг зохион байгуулах | Хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулах | Хуулийн үйлчлэлд хамаарах нийт төрийн албан хаагчдыг давтан сургасан байна. | АЗДТГ-ын ТЗУХ, ХЭЗХ | Бүх шатны төрийн байгууллагууд Аймаг, сумын ЗДТГ |
| Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх; | 6 | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэх батлуулах | Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчилсэн байх | | АЗДТГ-ын ТЗУХ | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| | 7 | Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | Сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангасан байх | | АЗДТГ-ын ТЗУХ, ХЭЗХ | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 8 | “E-Khutuch” эрх зүйн туслалцааны цахим хуудсанд аймагт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн акт, төсөл, хөтөлбөр тухайн орон нутгийн төрийн байгууллагаас нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг байршуулах ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэх, мэдээлэх | Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Төрийн байгууллагаас нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг байршуулсан байна. | АЗДТГ-ын ХЭЗХ | Аймаг, сумын ЗДТГ |
| | 9 | Иргэд, байгууллагын, Авлигын эсрэг хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн мэдлэг, мэдээллийг авах нөхцөл боломжийг хангах зорилгоор “Нээлттэй Сэлэнгэ” төрийн үйлчилгээний цахим лавлахыг хэрэглээнд нэвтрүүлэх | Мэдээлэл авах нөхцөл боломжийг бий болгох ажлыг зохион байгуулах | Иргэд, байгууллагууд мэдээллээр хангагдсан байна. | АЗДТГ-ын ТЗУХ, ХШҮДАХ | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| | 10 | Иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу цахим болон цаасан суурьтай баримтнаас архивын лавлагаа хуулбарыг олгох | Ажилласан жилийн лавлагаа, эхийн одонгийн лавлагаа, цалингийн тодорхойлолт архивын магадлагаа тодорхойлолт гаргаж үйлчлэх | Хэрэгжилт хангагдаж иргэд албан байгууллага шаардлагатай мэдээ, мэдээлэл авсан байна. | АЗДТГ-ын ХЭЗХ, Архивын тасаг | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| | 11 | Сумдтай цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | Хөтөлбөрийн дагуу сургалт зохион | | АЗДТГ-ын бодлогын хэлтсүүд | Аймаг, сумын ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулах | | | |
| 4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох; | 12 | Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх | Хяналт шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах | Хяналт шалгалтын тоо цөөрсөн байна. | Аймгийн Аудитын газар, Мэргэжлийн хяналтын газар, Санхүүгийн хяналт, аудитын алба | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага |
| 4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах. | 13 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | Үнэлгээ хийлгүүлэх ажил хэвшсэн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| | 14 | Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэнээр үнэлүүлэх ажлыг зарим сум, агентлагуудад зохион байгуулах | Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэд үнэлгээ өгдөг болсон байх | Иргэд үнэлгээ өгч хэвшсэн байна. | АЗДТГ-ын ТЗУХ, ХШҮДАХ | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.3.1.улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх; | 15 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, сум, байгууллагаар ангилан олон нийтэд мэдээлэх | Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг олон нийтэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах | Аймгийн цахим хуудас, мэдээллийн самбар, цахим дэлгэцээр мэдээлэгдсэн байна. | АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 4.1.3.4.төсвийн төсөл | 16 | Орон нутгийн төсвийн | Орон нутгийн | Төсвийн төсөлд | АЗДТГ-ын | Аймаг, сумын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах; | | төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах | төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх нөхцлийг бүрдүүлэх | олон нийтийн саналыг тусгаж хэвшсэн байна. | Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс | ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, |
| | 17 | Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэх | Цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр төсвийн төсөлд санал авах боломж нөхцлийг бүрдүүлэх | Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байна. | АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын алба | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, |
| 4.1.3.7.аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах; | 18 | Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх ажлыг зохион байгуулах | Хариуцлагыг тооцсон байх | - | Төрийн албаны салбар зөвлөл | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| **Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 4.1.4.1.тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх; | 19 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, худалдан авах ажиллагааг 100 хувь цахим системээр мэдээлэх ажлыг зохион байгуулах | Аймгийн цахим хуудсаар тогтмол мэдээлэх ажлыг зохион байгуулах | Тендерийн холбогдолтой мэдээлэл аймгийн цахим хуудсаар мэдээлэгдсэн байна. | ХОХБТХ, ОНӨГ | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| **Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.5.13.хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх; | 20 | Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгч ажиллах | Авлигын эсрэг хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах | ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлсэн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| | 21 | Хууль сахиулах байгууллагуудын хамтарсан уулзалтыг зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцож, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжруулах, авлигын эсрэг самбар гаргаж байршуулах | Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Ажил хэргийн уулзалт зохион байгуулагдсан байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Хууль сахиулах байгууллагууд | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.6.1.хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, дэлхийн эдийн засгийн форумын авлигын эсрэг түншлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх; | 22 | Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжиж, Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний болон аймгийн хөтөлбөрийг сурталчлах ажлыг хамтран зохион байгуулах | Авлигын эсрэг сүлжээг бий болгох | Авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжиж соён гэгээрүүлэх ажлыг хамтран зохион байгуулсан байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, ИНБ-ууд | Аймаг, сумын ЗДТГ |
| Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.7.2.төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил тод, | 23 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар | Хувийн хэвшил, иргэний нийгмийн | Иргэний нийгмийн байгууллагуудаар төрийн зарим чиг үүргийг | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | ИНБ-ууд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| нээлттэй болгох чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох; | | гүйцэтгүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх | байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах | гүйцэтгүүлсэн байна. | | |
| | 24 | Иргэд, байгууллагын, Авлигын эсрэг хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн мэдлэг, мэдээллийг авах нөхцөл боломжийг хангах зорилгоор аймгийн цахим хуудас, аймгийн ЗДТГ-ын улирал тутмын "Өргөн Сэлэнгэ" мэдээллийн сэтгүүлд мэдээлэл нийтлэх | Хууль тогтоомж сурталчлах ажлыг зохион байгуулах | Хэрэгжилт хангагдаж иргэд мэдээ, мэдээлэл авсан байна. | АЗДТГ-ын ТЗУХ, ХШҮДАХ | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх; | 25 | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Хууль тогтоомж сурталчлах ажлыг сар бүр зохион байгуулах | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах ажиллагааг иргэн, ТББ-аар гүйцэтгүүлсэн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Сумдын ЗДТГ,<br>Иргэд, төрийн бус байгууллага |
| | 26 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг хууль зүйн туслалцааны төвтэй хамтран зохион байгуулах | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх | Шударга байдлын үнэлгээ өссөн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| | 27 | Төрийн байгууллага бүрийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний | Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл | Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өссөн | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийн үр дүнг сайжруулах ажлыг зохион байгуулах | ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх | байна. | | байгууллага, ОНӨААТҮГ |
| | 28 | ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулах | Сургалт зохион байгуулсан байх | Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 4.1.10.2.боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах; | 29 | Ерөнхий боловсролын сургуулиудад шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих сэдэвт сургалтыг зохион байгуулах | Сурагчдын нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон сургалтыг зохион байгуулах | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлсэн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, БСУГ | Сумдын ЗДТГ, ерөнхий боловсролын сургуулиуд |
| | 30 | Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зарим сумдад зохион байгуулах | Шударга ёс сэдэвт арга хэмжээнүүд зохион байгуулах | Хүүхэд, залуучуудын шударга зан чанар, ёс суртахууны үнэлэмж дээшилсэн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, БСУГ, ГБХЗХГ | Аймаг,сумын болосролын байгууллагууд |
| 4.1.10.4.авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах; | 31 | Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх сургалтад хамрагдах | Сургагч багш нарыг бэлтгэх сургалтад хамрагдсан байх | Сургагч багшийн тоог нэмэгдүүлсэн байна. | АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС**

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр Дугаар А/149 Сүхбаатар сум

Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг
2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.“а”, Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлах тухай 51 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 01/475 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор тайлагнахыг сум, агентлагийн дарга нар, нийт төр, төсөв орон нутгийн өмчийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ОРГИЛ

БАТЛАВ:
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ш.ОРГИЛ

2019 оны 04 дүгээр сарын 19 ний өдөр

МЮА0005 9055053

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АВЛИГЫН ЭРСДЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийх ажил | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран зохион байгуулагч |
|---|---|---|---|---|
| 1 | Авлигатай тэмцэх газрын 2019 оны 01/475 зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө гарган баталгаажуулах | 03-р сард | Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ |
| 2 | Хуульд эрх хэмжээ олгоогүй байхад захиргааны хэм хэмжээний актыг тогтоон мөрдүүлэх, хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, хуулиар хэм хэмжээний акт тогтоох эрхгүй этгээд дүрэм, журам батлан мөрдүүлж, иргэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг журамлах, төлбөр хураамж тогтоох зэрэг зөрчил нийтлэг гарч байгааг таслан зогсоож арилгах, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх. | Жилдээ | Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ |
| 3 | Засаг даргын нөөц хөрөнгийг хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.3.2 /төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх/-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | Жилдээ | Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 4 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хэрэгцээ, | Жилдээ | Аймгийн ЗДТГ-ын | Аймаг, сумын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | шаардлага, эдийн засгийн үр дагаврыг тооцох, алдагдалтай ажиллаж буй байгууллагыг өөрчлөх, нэгтгэх, татан буулгах зэргээр төсөв, санхүүгийн зардал, төсвөөс олгох татаасыг үе шаттайгаар бууруулах, санхүүгийн хариуцлагыг чангатгах чиглэлээр тодорхой ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,<br>Санхүү, төрийн сангийн хэлтэс,<br>Орон нутгийн өмчийн газар | ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 5 | Аймгийн хэмжээнд ашигт малтмал, уул уурхайн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын болон бичил уурхайгаар ашигт малтал олборлох үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах. | Жилдээ | Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,<br>Мэргэжлийн хяналтын газар, | Аймаг, сумын ЗДТГ,<br>БОАЖГ,<br>ГХБХБГ |
| 6 | "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын хэрэгжилтийг хангаж, ТЭЗҮ, зураг, төсөв иж бүрэн хийгдсэн төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар нь тухайн жилийн орон нутгийн төсвийг батлах асуудалд санал санаачлагатай нээлттэй, ил тод байдлыг хангаж оролцох. | Жилдээ | АИТХ-ын ажлын алба,<br>Аймаг сумын ЗДТГ,<br>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,<br>Санхүү, төрийн сангийн хэлтэс, | Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, |
| 7 | Төсөл арга хэмжээний хэрэгцээ, шаардлага, хөрөнгийн эх үүсвэрийг бодитоор тооцсоны үндсэн дээр хуулиар тогтоосон хугацаанд төлөвлөж батлуулах, Засгийн газраас баталсан "босго үнэ"-д багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулж байгааг таслан зогсоох. | Жилдээ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,<br>Санхүү, төрийн сангийн хэлтэс,<br>Орон нутгийн өмчийн газар | Аймаг, сумын ЗДТГ |
| 8 | Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагчдыг сургах, чадавхижуулах, гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй хуулийн этгээдийг Сангийн яаманд бүртгүүлж хэвших чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах. Хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд төсвийг захиран зарцуулахад анхаарч, зөрчил дутагдлыг дахин давтахгүй байх. | Жилдээ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,<br>Санхүү, төрийн сангийн хэлтэс,<br>Орон нутгийн өмчийн газар | Аймаг, сумын ЗДТГ |
| 9 | Гэрээг цаг хугацаанд нь дүгнэж, гэрээнд заасан хугацаанд ажлаа хийж гүйцэтгээгүй аж ахуй нэгжтэй алданги тооцож хэвших. | Жилдээ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | Төсөл арга хэмжээний худалдан авалтын аргыг оновчтой зөв хэрэглэх, төсвийг, үр ашиггүй зарцуулахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх. | Жилдээ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,<br>Санхүү, төрийн сангийн хэлтэс,<br>Орон нутгийн өмчийн газар | Аймаг, сумын ЗДТГ |
| 11 | Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд нэр бүхий албан хаагчдыг тогтмол ажиллуулж байгаа нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэл дагуулж болзошгүйг анхаарч, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг сургах, чадавхижуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах. | Жилдээ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,<br>Орон нутгийн өмчийн газар | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 12 | Аудитын байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар төсөв санхүүгийн эх үүсвэрийг зориулалтын бус, үр ашиггүй зарцуулсан зөрчил түгээмэл, хүргүүлсэн зөвлөмжийн дагуу тодорхой үр дүнтэй арга хэмжээ аваагүй нь авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах эрсдэл үүсгэж байгаа тул төсөв санхүүгийн хариуцлага, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг чангатгах, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх | Жилдээ | Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс,<br>Санхүүгийн хяналт, аудитын алба | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 13 | Албан тушаалтан томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр салбарын хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох, хяналтыг сайжруулах. | Жилдээ | Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 14 | Төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохдоо мерит зарчмыг удирдлага болгох, албан тушаалаас чөлөөлөхтэй холбогдуулан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх. | Жилдээ | Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс,<br>Хууль, эрх зүйн хэлтэс | Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ |
| 15 | Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн | Жилдээ | Аймаг, сумын ЗДТГ | Төрийн бус байгууллага, иргэд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр зэрэг холбогдох дүрэм журмуудыг мөрдөн ажиллах | | | |

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР